




**МУШГИХ МОМЕНТЫН ШИЙДЭЛҮҮД
0,04 – 54.000 Нм**

БҮХ ХҮЧИЙГ НЭГ ДОРООС АВАХ БОЛОМЖ

Аюулгүй ажиллагаа, өндөр нарийвчлал МУШГИХ МОМЕНТООР ЧАГНАХ АЖИЛД

Аж үйлдвэр, цех, засварын газруудад эд ангиудыг холбож боох ажиллагаанд өндөр нарийвчлалтай техникийн шаардлага тавигдах нь улам бүр түгээмэл болж байна. Ийм шаардлага тавигдах болсон шалтгаан нь олон хүчин зүйлтэй холбоотой. Үүнд: ашиглагдах материалын төрөл, хүрээлэн буй орчны нөхцөл, хэрэглээний онцлог, буцаж мөшгөх (трасс) шаардлага, процессын найдвартай байдал зэрэг багтана. Эдгээр нөхцөлөөс хамааран тохирсон, оновчтой багаж хэрэгслийг зөв сонгож ашиглах нь өндөр ач холбогдолтой.

Мушгих моментын багаж нь энгийн, стандарт болон нарийн төвөгтэй чангалаа хийхэд тохиромжтой шийдэл болдог. Ингэснээр боолтыг технологийн дагуу найдвартай чангальж, шаардлагатай үед гэмтээлгүйгээр суллах боломжтой. Ийм ажиллагаа нь материал хэмнэх, эдийн засгийн үр ашигтай байх, үйлдвэрлэлийн процессын найдвартай байдлыг хангах давуу талтай. Мөн хэрэглэхэд хялбар, найдвартай мушгих моментын багажууд нь өндөр нарийвчлал шаардсан ажлуудад тохиромжтой. Үүний зэрэгцээ холбогдох техникийн стандарт, дүрэм журамд нийцсэн байдлаар үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн хэрэгцээг хангах чухал үүрэгтэй.



ГЕДОРЕ БРЭНД НЬ 0,04 НМ-ААС 54.000 НМ ХҮРТЭЛХ БҮХ ТӨРЛИЙН БООЛТНЫ ЧАНГАЛГААНД НАРИЙВЧЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА.

ГЕДОРЕ брэнд нь 0,04 Нм-аас 54.000 Нм хүртэл мушгих момент шаардсан бүх төрлийн боолтны чангалаанд нарийвчлал, аюулгүй ажиллагааг санал болгодог. Бид өндөр нарийвчлалтай мушгих моментын багажийн өргөн сонголттой. Мөн хэрэглэгчийн тусгай хэрэгцээнд нийцсэн шийдэл, сервис үйлчилгээг үзүүлдэг. Дижитал болон механик ажиллагаатай мушгих моментын багаж хэрэгслүүдээр бүх төрлийн чангалааны шаардлагыг хангана.

ГЕДОРЕ нь 100 гаруй жилийн туршлагатай багаж, этлон төхөөрөмж үйлдвэрлэгч юм. Бид мэргэжлийн хэрэглээнд зориулсан гар багаж болон этлон төхөөрөмжүүдийг хөгжүүлэн үйлдвэрлэх байна. Манай багаж хэрэгслүүд боолтыг өндөр нарийвчлалтай чангальж, чангалааны үр дүнг бүртгэх боломжийг олгодог. Мөн материалыг дахин ашиглах нөхцөлийг бүрдүүлдэг. Бид мушгих моментын нарийвчлалтай чангалаа, чангалааны бүртгэл, хяналт хийх иж бүрэн шийдлийг санал болгодог. Мөн этлон төхөөрөмж, мушгих моментын багаж, огц хэмжилт, шинжилгээ, зөвлөгөө зэрэг мэргэжлийн үйлчилгээг үзүүлдэг. Бид таны чангалааны бүх төрлийн шаардлагад нийцсэн найдвартай шийдлийг санал болгоно.



APPLICATION CENTER TORQUE

Хэрэглэгчдийн тавьж буй тусгай шаардлагыг түргэн шуурхай, үр бүтээлтэй хангах зорилгоор бид 2021 онд "GEDORE Application Center Torque" төвийг байгуулсан. Энэхүү төвийн хүрээнд боолтны технологийн улам бүр төвөгтэй болж буй шаардлагуудад илүү онцгой анхаарал хандуулах үндэс суурийг амжилттай тавьсан. Ингэснээр манай хэрэглэгчид болон борлуулалтын түншүүд илүү богино хугацаанд хөгжүүлэлт, шийдлийг хүлээн авахын зэрэгцээ өндөр түвшний инновациын давуу талыг хүртэх боломжтой болсон.

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА ЯМАР Ч ЭРГЭЛЗЭЭГҮЙ


Бид зах зээлийн өргөн хүрээнд 0.04 - 54,000 Нм хүчин чадал бүхий мушгих моментын багаж, төхөөрөмжийг санал болгодог. Эдгээр багаж, төхөөрөмжүүд нь тухайн салбарын онцлогт тохирсон, оновчтой шийдэл бүхий аюулгүй, баталгаатай мушгих моментын системүүд юм. ГЕДОРЕ брэндийн үйлдвэрлэлийн стандарт нь олон улсын норматив шаардлагыг давсан өндөр түвшний техникийн үзүүлэлттэй. Бидний үйлдвэрлэсэн багаж, төхөөрөмжүүд нь хэмжилтийн нарийвчлал өндөртэй, стандарттаас давсан найдвартай чанартай байдаг.

ЗАРДАЛЫГ ХЯНАНА

Үйлдвэрлэлд шаардлагатай боолтны чангалах хэмжээсийг нарийвчлан шалгах нь маш чухал. Зөв хэмжээсийг тодорхойлохын тулд чангалаанд технологийн шинжилгээ хийх шаардлагатай. ГЕДОРЕ-ийн дижитал мушгих моментын шийдлүүд нь таны хэрэглээнд тохирсон нарийвчилсан шинжилгээ хийх боломж олгодог. Эдгээр шийдлүүд нь үйлдвэрлэлийн процессыг оновчтой болгож, эдийн засгийн хэмнэлтийг бий болгодог. Холболтын төрөл, тооноос үл хамааран жижиг хэмжээтэй чангалаа ч ашиглалтын зардлыг мэдэгдэхүйц бууруулахад нөлөөлнө. ГЕДОРЕ нь бүх процессын явцад таны найдвартай түнш байх болно.

БАТАЛГААЖСАН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Бид таны мушгих моментаар хэмжих багаж, тестер төхөөрөмжийг DIN EN ISO 6789-2:2017 стандартын дагуу баталгаажуулж тохиуулна. Мөн үйлдвэрийн техникийн онцлох үзүүлэлтүүд болон DIN, DAkkS, UKAS зэрэг олон улсын шаардлагын дагуу тохиргоо, шалгалт хийж, сертификат гаргаж өгнө. Мушгих моментын багаж, тестер төхөөрөмжийг үе шаттайгаар тестлэх, шалгах нь буцаж мөшгөн (трасс) үйлдлийг баталгаажуулж, процессын найдвартай байдлыг хангахад чухал ач холбогдолтой. ГЕДОРЕ нь хэрэглэгчдэд өөрийн бие даасан тестлэх хугацааны мөчлөг-өөр багаж, төхөөрөмжкөө тогтмол баталгаажуулж байхыг зөвлөдөг.



ЭХЭЛСЭН ЦАГААСАА ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭСЭН: TOOLS FOR LIFE

ГЕДОРЕ нь 100 гаруй жилийн турш багаж хэрэгслийг зохион бүтээж, үйлдвэрлэхдээ ашиглалтын хугацааг урт хугацаанд байхаар тооцон бүтээдэг. GEDORE брэнд хамгийн өндөр чанар, аюулгүй байдлыг эрхэмлэсний үр дүнд өнөөг хүртэл хэрэглэгчдийн итгэлийг хүлээсээр байна. Манай мушгих моментын багажуудыг хэрэглэгчид хэдэн арван жилийн турш ашиглаж байгаа бөгөөд эдгээр багажуудын ажиллагаа нь анхны өдрийн шигээ хэвийн, найдвартай хэвээрээ байдгийг бид бахархалтайгаар тэмдэглэдэг. Бидний үндсэн зорилго бол хамгийн өндөр чанартай мушгих моментын шийдлүүдийг хөгжүүлж, үйлдвэрлэж, борлуулж, тохирлын сервис үйлчилгээ үзүүлэхэд оршдог. Мөн бид хуучны загварын багаж хэрэгслийг засварлан шинэчилж, дахин ашиглах боломжийг олгож байна. Ингэснээр бид байгаль орчиндоо ээлтэй байж, байгалийн нөөцийг хэмнэхэд хувь нэмэр оруулж байна.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ПРОЦЕССИЙН ИНТЕГРАЦ

Та манай мэргэшсэн мушгих моментын экспертуудийн хамтаар найдвартай талд байна, бид таны боолт болгоны чангалаанд зөвлөгөө өгч чадна, үүнд шаардлагатай мушгих моментын багажийг зөв сонгох, үйлдвэрлэлийн процесст нэгтгэх, хэмжилтийн дата өгөгдлийг цаашид боловсруулах гэх мэт, иймээс бидэнд 0.04-өөс 54,000 Нм хүртэл мушгих моментын хүчиний шийдэл байна.

МУШГИХ МОМЕНТ ТЕХНОЛОГИЙН ИРЭЭДҮЙ

ГЕДОРЕ нь дижитал болон электрон мушгих моментын шийдлүүдийг үйлдвэрлэлд нэвтрүүлж эхэлсэн цагаасаа хойш дата бүртгэл, шинжилгээ, хэмжилтийн сан бүрдүүлэлт зэрэг бүх өгөгдлийг стандартжуулсан. Бид үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээг ойлгож, үйл явцтай нь уялдуулах зорилгоор өндөр хүчин чадалтай программ хангамжийг ашиглан ажиллаж байна.

Үргэлж өсөн нэмэгдэж буй дижитал хэрэглээ болон хэрэглэгчдийн шинэ шаардлагыг хангах үүднээс бид хамтран ажилладаг.


Мушгих моментын оновчтой шийдэл, сервис үйлчилгээг хэрэглэгчдийн хамт тасралтгүй хөгжүүлэх болно.

Цаашид дижитал болон виртуал орчноор дамжин үйлдвэрийн орчинд зочлох, дата дамжуулах, ухаалаг үүлэн системд суурилсан мушгих моментын шийдлийг нэгтгэх зэрэг боломжуудыг бий болгоно.

Ирээдүйн дижитал шийдэлд бидэнтэй хамт нэгдээрэй.

МЭДЛЭГТ СУУРИЛСАН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Анхан шатны суурь мэдлэгээс эхлээд нарийн төвөгтэй хэрэглээнд шаардлагатай бүх шатны сургалтыг бид санал болгож байна. Манай мэргэшсэн мушгих моментын мэргэжилтнүүд таны хэрэгцээнд нийцсэн сургалтыг дэлхий даяар хүргэн зохион байгуулдаг. Бид тогтвортой сургалтын үзэл баримтлал болон бодит практикт тулгуурласан жишээ ашиглан сургалтаа явуулдаг. Ингэснээр та мушгих моментын технологийн нарийн төвөгтэй ойлголтуудыг хялбар бөгөөд үр дүнтэйгээр эзэмших боломжтой. Бид таныг энэ чиглэлд мэргэшсэн мэргэжилтэн болоход тань тусална.



0,04 -
100

Нм


БАГА хүчний мушгих моментын шийдэл



**Электрон эд ангиудыг угсрах, анагаах ухааны салбар,
лаборатори гээд хаана ч байсан**

Жижиг эд анги болон мэдрэмтгий эд ангиудын боолтыг чангалах үед мушгих моментын хэмжээ ихэвчлэн маш бага байдаг. Ийм боолтыг өндөр нарийвчлалтай мушгих моментын хүчээр ачаалах шаардлагатай.

Ингэснээр жигд, найдвартай, материалын хорогдолгүй холболт хийх боломжтой болдог. ГЕДОРЕ нь 0,04 Нм-ээс 100 Нм хүртэл мушгих моментын багажийг санал болгодог. Эдгээр багаж нь цуврал үйлдвэрлэлийн хэрэгцээ болон өндөр нарийвчлалтай, бага мушгих момент шаардсан угсралтын ажилд зориулагдсан.



ҮР ЧАДВАРЫН НОТОЛГОО

TSN Slipper загвар нь "Slipper" технологийн үндсэн дээр ажилладаг бөгөөд тохируулсан мушгих моментын хэмжээнд хүрмэгц сүл эргэлтэд шилжиж, тохирсон моментаас хэтрүүлэн чангалах эрсдэлээс бүрэн хамгаална.



ДҮНД хүчний мушгих моментын шийдэл



Үргэлж зөв мушгих моментын шийдэл — энгийн мушгих моментын түлхүүрээс эхлээд хөнгөн цагаан хийцтэй дремометр загвар хүртэл. Дремометр загварын хувьд уртаас үл хамаарах буюу багажийн урт, барих байрлалаас үл шалтгаалах өндөр нарийвчлалтай мушгих моментын шийдэл юм.

ГЕДОРЕ нь 10 Нм-аас 3000 Нм хүртэлх мушгих моментаар чангалах бүх салбарт зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгодог. Эдгээр нь энгийн, стандартчилагдсан металл хийцийг холбох боолтоос эхлээд дахин ашиглах боломжтой төрөл бүрийн боолт, цуврал үйлдвэрлэлийн хэрэгцээ, хэрэглэгчдэд зориулсан тусгай шийдлийг багтаана. Бид боолтыг аюулгүй, дахин ашиглаж чангалах бүхий л шат дамжлагад таны найдвартай хамтрагч байх болно.



УР ЧАДВАРЫН НОТОЛГОО

ГЕДОРЕ зах зээлд хөнгөн цагаан хийцтэй, уртаас үл хамаарах дремометр загварын мушгих моментын түлхүүрийг санал болгодог.

**90 -
54.000**

Нм


ИХ хүчний мушгих моментын шийдэл



Их хүчээр чангалах шаардлага хүнд үйлдвэр, уул уурхайн техник, баяжуулах үйлдвэр, барилга угсралт, дэд бүтэц зэрэг олон салбарт түгээмэл тохиолддог. Ийм мушгих моментын чангалааг найдвартай, аюулгүй, хүний биед ачаалал ёгөхгүйгээр гүйцэтгэх нь зайлшгүй шаардлагатай.

ГЕДОРЕ нь 90 Нм-аас 54,000 Нм хүртэл мушгих моментын хүчин чадал бүхий багажийг энэ ангилалд зохион бүтээж, үйлдвэрлэдэг. Зэвэрч гацсан боолт ч бай, онцгой нэхцэлд ажиллах шаардлага ч бай, бидэнд тохирсон шийдэл бий.

Бидний бүх мушгих моментын шийдлүүд нь боолтыг найдвартай, аюулгүй, өндөр нарийвчлалтайгаар чангалах болон буцаан суллах боломжтой байдлаар тооцоолон бүтээгдсэн. Мөн ус сувгийн шугам болон төвлөрсөн дулааны шугам хоолойн хаалтыг нээж, хаахад зориулагдсан тусгай загварын багажуудыг боловсруулан санал болгож байна.



УР ЧАДВАРЫН НОТОЛГОО

ГЕДОРЕ-ийн хаалтанд зориулсан тусгай загвар нь гариг араатай хүч дамжуулах хурдны хайрцагтай. Үүний онцлог нь асаах болон унтраах үед зөөлөн эргэлтэд ордог найдвартай ажиллагаа юм.



ИХ ХҮЧНИЙ МУШГИХ МОМЕНТ

ЗАГВАР	НМ	АШИГЛАХ ЗОРИУЛАЛТ	ДЭЛГЭЦ	ХҮЧДЭЛ	НЭМЭЛТ
GDA	60 250	УНИВЕРСАЛ	Аналог	Батарей	
GDA Solution	70 300	УНИВЕРСАЛ	Дижитал	Батарей	Баримтжуулалт
LDE-S/LEW-S	770 900	ХААЛТНЫ	Дижитал	Цахилгаан	
LDA-S Solution/ LAW-S Solution	500 1.200	ХААЛТНЫ	Дижитал	Батарей	Баримтжуулалт
LDA-S/LAW-S	500 1.200	ХААЛТНЫ	Аналог	Батарей	
LES	1.600 4.800	УНИВЕРСАЛ	Дижитал	Батарей	
LPS	3.000 4.800	УНИВЕРСАЛ	Дижитал	Хийн	
LDA/LAW	90 6.000	УНИВЕРСАЛ	Дижитал	Батарей	
LDA Solution/LAW Solution	90 6.000	УНИВЕРСАЛ	Дижитал	Батарей	Градус заалт, Баримтжуулалт
LHD	800 7.500	УНИВЕРСАЛ	Дижитал	Батарей	Градус заалт, Баримтжуулалт
LPK/LPK-X	80 12.800	УНИВЕРСАЛ	Аналог	Хийн	
LDE/LEW	90 13.000	УНИВЕРСАЛ	Дижитал	Цахилгаан	Градус заалт, Баримтжуулалт
LDK	160 24.000	УНИВЕРСАЛ			Гидраулик
LDH	60 27.000	УНИВЕРСАЛ			Гидраулик
LHU Гидраулик төхөөрөмж M, A, S		УНИВЕРСАЛ	Аналог (M, A) Дижитал (S)	Гидраулик	Баримтжуулалт (S)
Контортулхүүр		УНИВЕРСАЛ			



ХҮЧ ӨСГӨГӨЧ

Загвар	Нм	Ашиглалт	шаталсан хэлбэртэй тулаас	шулуун хэлбэртэй тулаас	Буцалтын түгжээ	Сертификат
DVI-20Z (L) - DVI-28Z (L)	100 2.800	универсал				●
DVV-13Z (G) - DVV-40Z	50 4.000	универсал	стандарт	сонголт		●
DVV-40ZRS	500 4.000	универсал	стандарт	сонголт	●	●
DVV-60RS - DVV-80RS	650 8.000	универсал	стандарт	сонголт	●	●
DVV-100RS - DVV-130RS	1.000 13.000	универсал	стандарт		●	●
DVV-540RS	5.000 54.000	универсал	стандарт		●	



Мушгих моментын автирк & Мушгих моментын түлхүүр


ЗАГВАР	Нм		НЭГЖ	АШИГЛАХ ЗОРИУЛАЛТ	ТӨРӨЛ	ДЭЛГЭЦ	НЭМЭЛТ	
PRIME, PRO, TLS, QSN, QS, TT	0.04	13.5	cNm / Nm	Цуврал угсралт, Чанар шалгалт	Механик / Заалт	Аналог	EPA Protected	(Electronic Area)
VDE 1.000 V	5	50	Nm	Универсал	Механик		VDE / 1.000 Volt	
TSN, TSC	1	125	Nm / lbf.in	Цуврал угсралт	Механик		Сул эргэх үйлдэлтэй	
TT3KH	10	350	Nm / lbf.in	Универсал	Заалт	Дижитал	Мушгих момент / Градус, Баримтжуулалт	
TF-K, TF-SE, TF-Z	1	850	Nm / lbf.ft	Универсал	Механик			
DMK, DMUK, DMZ, DMSE	7	850	Nm / lbf.ft	Универсал	Механик			
ETQ, ETQR	0.25	1000	Nm / lbf.in	Чанар хяналт, Анализ	Механик	Дижитал	Олон төрлийн Анализ үйлдэл	
TBN, Typ 88	0.4	1000	Nm / lbf.in	Цуврал угсралт	Механик		Нүграх үйлдэлтэй	
ET2SKA, ET2ZA	2	1000	Nm / lbf.in	Универсал +. Чанар хяналт болон анализ	Заалт	Дижитал	Олон төрлийн хэмжих болон Анализ үйлдэл	
Typ 83	0.8	2000	Nm / lbf.in / lbf.ft	Универсал+ Чанар хяналт Анализ	Заалт	Аналог	Зүүн заалтын үйлдэл	
DR, Нэг болон хоёр тальн ажилгаатай, Z, SE, A+S, T-FS	2,5	3000	Nm / lbf.in / lbf.ft	Универсал, Цуврал угсралт	Механик		Уртын хамааралгүй / уртасагчтай	

Хүнд хүчир нөхцөлд шалгарсан DREMOMETEP загвар 6 - 3000Нм



ТЕСТЕР

Загвар	Нм		Нэгж	Ашиглах зориулалт	Зориулалт	Хэмжих төрөл	Баримжуулалт
CAPTURE LITE	0.02	350	Nm / lbf.in / lbf.ft	Магадлан шалгалт Завсрын шалгалт	Моментын түлхүүр Моментын автирк	Track, 1. Peak, 2. Peak	
CAPTURE HUB	0.1	1.500	cNm / Nm / ozf.in / lbf.in / lbf.ft	Магадлан шалгалт Завсрын шалгалт Сертификатын шалгалт	Моментын түлхүүр Моментын автирк Elektro-, Abschalt- und Impulsschrauber	Track, 1. Peak, 2. Peak	
DREMOTEST-E	0.2	3.150	Nm / lbf.in / lbf.ft	Магадлан шалгалт Завсрын шалгалт	Моментын түлхүүр	1. Peak	
E-TP (Elektronisches Torsions-Prüfgerät)	0.5	3.150	cNm / Nm / lbf.in / lbf.ft	Магадлан шалгалт Завсрын шалгалт Сертификатын шалгалт	Моментын түлхүүр Моментын автирк	Track, 1. Peak, 2. Peak	



Боолтоос цаадахыг харсан ХҮЧТЭЙ ХОЛБООС

Танд ямар нэгэн БОНУС хэрэгтэй юм уу?
Итгэл найдвартай бизнесийн харилцагч уу?

Мушгих моментын багажийн аюулгүй ажиллагаа, урт хугацааны найдвартай эдэлгээ нь зөвхөн худалдан авалтын үйл явцаас ч илүү чухал ач холбогдолтой. Таны мушгих моментын багажийг үргэлж бэлэн байлгах, нарийвчлал, найдвартай ажиллагааг хангах, хэмжил зүйн үзүүлэлтийг тогтвортой баталгаатай байлгах үүднээс бид танд өргөн хүрээний туршилтын төхөөрөмж, тохиргоо, сервис, засвар үйлчилгээний иж бүрэн шийдлийг санал болгож байна.

Бид таны бүх төрлийн мушгих моментын багаж, төхөөрөмжийг DIN EN ISO 6789-2:2017, DAkkS, UKAS (BS 7882) стандартын шаардлагын дагуу шалгаж, тохируулж, баталгаажуулж өгнө. Ингэснээр та үйлдвэрлэлийн үйл явц дахь аюулгүй ажиллагааг сайжруулж, эрсдлийг бууруулж, эдийн засгийн бодит хэмнэлт бий болгох боломжтой. Мөн манай мэргэжилтнүүд таны хамтран ажиллагчаар байж, 0.04 - 54,000 Нм хүртэл мушгих моментын хүчээр боолтыг чангалах, суллах бүх шатны техникийн шийдэл, даатгал, зөвлөгөөг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх болно. Бид бүтээгдэхүүнээс давсан, урт хугацааны үнэ цэнтэй сургалтын үйлчилгээ үзүүлж, таны багийг мэргэшүүлэхэд бэлэн байна.

Мушгих момент, хүчний моментын тохиргоо, калибрейшн

- Мушгих моментын багажийн калибрейшн, тохиргоо болон засварын үйлчилгээ
- ГЕДОРЕ үйлдвэрийн болон DAkkS итгэмжлэгдсэн калибрейшн үйлчилгээ
- ГЕДОРЕ үйлдвэрийн DAkkS итгэмжлэлтэй лабораториид хийх нарийвчлал өндөр калибрейшн
- UKAS итгэмжлэлтэй калибрейшн үйлчилгээ (BS 7882 стандартын дагуу)
- Аюулгүй ажиллагааг баталгаажуулах буцаж мөшгөх баримт (Traceability documentation)

ЗӨВӨЛГӨӨ СУРГАЛТ

- Бүтээгдэхүүний сонголт, хэрэглээний зөвлөгөө
- Боолтны анализ болон технологийн процессын оновчлол
- Чанаарын хяналтын системийн интеграци
- Мушгих моментын чиглэлээр мэргэшсэн экспертуудийн сургалт
 - Германы боолтны холбоо (Deutscher Schraubenverband) хамтран зохион байгуулдаг
- Стандарт, техникийн шаардлагад нийцсэн тусгай сургалтууд

ЧПМ ХХК
Эрчим хүчний гудамж 9-1
16103 Улаанбаатар
Утас: 70104883
И-мэйл : info@bagaj.mn